

БАТЛАВ.
“ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРОО”-НЫ ДАРГА

А.ТЛЕЙХАН

БАТЛАВ.
“СНАПСОЛ” ХХК-Н ЗАХИРАЛ

Д.ЭРДЭНЭЦОГТ

**СУРГАЛТЫН ТАНХИМЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /АУДИО СИСТЕМ/
СИСТЕМ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар ...54/ 20.

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь “Сургалтын танхимын тоног төхөөрөмж /аудио систем/”-ийг (цаашид “бараа” гэх) 23,683,000 /Хорин гурван сая зургаан зуун наян гурван мянган/ төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь сургалтын танхимын тоног төхөөрөмж аудио системийг 2020 оны 12 дугаар сарын 21-ээс 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн дотор нийлүүлж суурилуулж хүлээлгэн өгнө
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай
мэдэгдэл; Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

6. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. буюу 11,841,500 (Арван нэгэн сая найман зуун дөчин нэгэн мянга таван зуу) төгрөгийг нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ. Үлдэгдэл 50% буюу 11,841,500 (Арван нэгэн сая найман зуун дөчин нэгэн мянга таван зуу) төгрөгийг бараа нийлүүлж суурилуулсны дараа хүлээлцсэн актыг үндэслээд шилжүүлэх байдлаар төлбөрийг барагдуулна
8. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
9. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, мэйл хаяг болон факсаар харилцана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2А
Утас : 262551, 319317
Факс : 319335

Ажлын албаны дарга :
Г.Эрхэмбаяр
Гарын үсэг

ЗУГ-н дарга:
М.Мөнхтулга
Гарын үсэг

Ахлах нягтлан бодогч
М.Мандах
Гарын үсэг

ЗУГ-н мэргэжилтэн
Б.Батбаяр
Гарын үсэг

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“СНАПСОЛ” ХХК –ИЙН ЗАХИРАЛ


/Д.Эрдэнэцогт/

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Зориг сангийн байр, 4тоот

Утасны дугаар : 88088391

